

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/111/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 57120
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsGol@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.09.21 № 01/50
танай _____ -ны № _____ -т

МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.НЭРГҮЙ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймаг сумын Засаг даргын шийдвэрээр эзэмших эрх бүхий 1,069,007.0 м.кв хэмжээтэй 9,073,300.0 мянган төгрөгийн газар, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1,139,053.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй 21,339.5 мянган төгрөгийн зөрчил болон хөрөнгийн бүртгэл тайлагнал, худалдан авах ажиллагаа, дотоод хяналт хариуцлагатай холбоотой 83,869.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Бусад асуудлын хэсэг

Мөрөн сумын Засаг даргатай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 96 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

572404006?

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  АСРДЭНЗБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	175,748,133.37	185,176,933.37
33	АВЛАГА	66,274,923.37	25,924,623.37
33300	Татаас, санхүүжилтийн авлага	66,274,923.37	24,094,623.37
335	Бусад авлага	00.00	1,830,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,830,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	109,473,210.00	159,252,310.00
351	Түүхий эд материал	37,590,710.00	25,494,710.00
35110	Тусгай зориулалттай материал	37,590,710.00	25,494,710.00
354	Хангамжийн материал	71,882,500.00	133,757,600.00
35410	Бичиг хэргийн материал	8,894,100.00	1,589,100.00
35420	Аж ахуйн материал	39,188,400.00	26,186,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	75,000.00	75,000.00
35450	Барилгын засварын материал	3,927,000.00	9,940,000.00
35470	Бусад хангамжийн материал	19,798,000.00	95,967,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	23,053,572,756.06	30,410,644,314.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,053,572,756.06	30,410,644,314.86
392	Биет хөрөнгө	20,898,556,547.40	19,785,035,606.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,695,980,092.51	1,770,919,365.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-259,064,210.89	-310,518,651.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	63,299,999.00	58,399,999.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-37,040,416.83	-48,695,416.66
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	520,418,732.00	661,267,074.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-119,181,788.07	-268,159,472.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,202,060.00	135,400,060.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,518,359.59	-53,894,097.86
39209	Зам, гүүрний байгууламж	17,846,871,069.11	17,846,871,069.11
39210	Хуримтлагдсан элэгдэл	-4,572,808,046.51	-5,855,993,624.87
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,753,334,046.37	8,617,599,875.37
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,562,609,489.70	-3,339,833,435.27
39217	Ном	521,672,860.00	571,672,860.00
393	Биет бус хөрөнгө	2,155,016,208.66	10,625,608,708.78
39301	Программ хангамж	137,500.00	137,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-49,652.72	-95,486.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,192,506,000.00	10,669,466,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-37,577,638.62	-43,899,305.22
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	23,229,320,889.43	30,595,821,248.23
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	23,229,320,889.43	30,595,821,248.23
51	Засгийн газрын хувь оролцоо	23,229,320,889.43	30,595,821,248.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,594,753,898.45	11,668,053,898.45
51101	Өмч: - төрийн	2,594,753,898.45	11,668,053,898.45
512	Хуримтлагдсан үр дүн	20,258,276,262.31	18,551,476,621.11
51210	Өмнөх үеийн үр дүн	20,258,276,262.31	20,258,276,262.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,706,799,641.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	376,290,728.67	376,290,728.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	23,229,320,889.43	30,595,821,248.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,353,817,314.00	3,280,275,084.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,551,533.00	1,240,888,894.80
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,551,533.00	1,240,888,894.80

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	952,130,533.00	1,139,053,444.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	48,421,000.00	101,835,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,353,265,781.00	2,039,386,190.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,989,681.00	43,077,390.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,331,000.00	7,952,490.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,658,681.00	32,624,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,293,276,100.00	1,996,308,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,293,276,100.00	1,996,308,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,633,475,841.00	4,349,961,775.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,633,475,841.00	4,349,961,775.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,540,809,650.84	4,303,243,403.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	538,014,663.23	874,007,286.84
210101	Үндсэн цалин	409,860,906.19	545,965,917.90
210102	Нэмэгдэл	66,815,393.16	258,255,492.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,057,439.88	51,696,817.50
210104	Урамшуулал	20,280,924.00	18,089,058.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,138,264.13	109,679,000.00
210201	Тэтгэврийн даатгал	45,578,891.49	72,335,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,629,572.35	9,336,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,485,704.17	7,468,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,028,064.17	1,867,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,416,031.95	18,671,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,182,693.62	140,406,505.27
210301	Гэрэл, цахилгаан	6,608,027.27	6,712,705.00
210302	Түлш, халаалт	91,313,934.36	126,829,739.77
210303	Цэвэр, бохир ус	4,260,731.99	6,864,060.50
2104	Хангамж, бараа материалын зардал	46,960,729.04	49,715,667.10
210401	Бичиг хэрэг	15,638,000.00	17,847,640.00
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.00	15,005,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,326,970.04	7,709,875.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,995,759.00	9,152,602.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,133,150.00	46,199,955.00
210604	Урсгал засвар	21,133,150.00	46,199,955.00
2107	Томилолт, зочны зардал	3,410,700.00	17,738,000.00
210702	Дотоод албан томилолт	1,410,700.00	11,610,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	6,128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	269,642,891.00	508,674,556.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	265,369,143.00	503,439,094.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,612,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	191,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,748.00	293,512.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	52,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,924,000.00	3,085,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,492,326,559.82	2,556,822,432.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	205,350,398.00	258,052,047.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,833,600.00	2,693,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,284,142,561.82	2,296,077,385.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,666,190.16	46,718,372.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,959,837.00	30,764,980.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,312.00	00.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	10,765,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,222,525.00	19,999,580.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	52,706,353.16	15,953,392.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,706,353.16	15,953,392.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,279,658,527.00	1,069,686,691.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	981,124.85	637,112,950.01
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	981,124.85	3,062,500.01
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	634,050,450.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-981,124.85	-637,112,950.01
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,280,639,651.85	1,706,799,641.20

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	641,522,898.45	376,290,728.67	14,697,391,238.16	15,715,204,865.28
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,832,619,543.92	00.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,594,753,898.45	376,290,728.67	21,530,010,782.08	23,229,320,889.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,594,753,898.45	376,290,728.67	20,258,276,262.31	23,229,320,889.43
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	9,073,300,000.00	00.00	00.00	9,073,300,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,706,799,641.20	-1,706,799,641.20
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,668,053,898.45	376,290,728.67	18,551,476,621.11	30,595,821,248.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,386,062,463.37	2,105,661,113.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,386,062,463.37	2,105,661,113.37
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,786,363.37	109,352,313.37
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,331,000.00	7,952,490.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,455,363.37	98,899,823.37
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,293,276,100.00	1,996,308,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,293,276,100.00	1,996,308,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,385,192,463.37	2,046,463,113.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,385,192,463.37	2,046,463,113.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,226,251,349.84	1,975,650,117.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	538,014,663.23	874,007,286.84
210101	Үндсэн цалин	409,860,906.19	545,965,917.90
210102	Нэмэгдэл	66,815,393.16	258,255,492.59

210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,057,439.88	51,696,817.50
210104	Урамшуулал	20,280,924.00	18,089,058.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,106,812.05	109,679,000.00
210201	Тэтгэврийн даатгал	44,832,860.31	72,335,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,550,825.55	9,336,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,430,588.41	7,468,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,014,285.23	1,867,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,278,252.55	18,671,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,685,236.52	140,406,505.27
210301	Гэрэл, цахилгаан	6,608,027.27	6,712,705.00
210302	Түлш, халаалт	91,313,934.36	126,829,739.77
210303	Цэвэр, бохир ус	3,763,274.89	6,864,060.50
2104	Хангамж, бараа материалын зардал	45,322,729.04	48,815,117.10
210401	Бичиг хэрэг	14,000,000.00	16,952,640.00
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.00	15,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,326,970.04	7,709,875.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,995,759.00	9,152,602.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,000,000.00	46,222,955.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	23,000.00
210604	Урсгал засвар	21,000,000.00	46,199,955.00
2107	Томилолт, зочны зардал	3,410,700.00	17,738,000.00
210702	Дотоод албан томилолт	1,410,700.00	11,610,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	6,128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,049,211.00	495,067,031.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	257,775,463.00	489,631,569.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,612,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	191,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,748.00	293,512.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	52,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,924,000.00	3,285,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,661,998.00	243,714,222.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	185,828,398.00	241,021,222.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,833,600.00	2,693,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,941,113.53	70,812,995.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,959,837.00	30,764,980.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,312.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	10,765,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,222,525.00	19,999,580.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	118,981,276.53	40,048,015.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,981,276.53	40,048,015.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	870,000.00	59,198,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	870,000.00	59,198,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	870,000.00	59,198,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	870,000.00	59,198,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	870,000.00	59,198,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-870,000.00	-59,198,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,996,308,800.0	1,980,355,407.8	15,953,392.2	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,996,308,800.0	1,980,355,407.8	15,953,392.2	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,965,543,400.0	1,949,590,427.8	15,952,972.2	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	876,194,600.0	874,007,286.8	2,187,313.2	99.8
210101	Үндсэн цалин	597,519,600.0	545,965,917.9	51,553,682.1	91.4
210102	Нэмэгдэл	219,275,000.0	258,255,492.6	-38,980,492.6	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,400,000.0	51,696,817.5	7,703,182.5	87.0
210104	Урамшуулал	00.0	18,089,058.9	-18,089,058.9	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,679,000.0	109,679,000.0	00.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	72,335,300.0	72,335,300.0	00.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,336,000.0	9,336,000.0	00.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,468,700.0	7,468,700.0	00.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,867,200.0	1,867,200.0	00.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	18,671,800.0	18,671,800.0	00.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,842,600.0	140,406,505.3	4,436,094.7	96.9
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.0	6,712,705.0	2,287,295.0	74.6
210302	Түлш, халаалт	128,842,600.0	126,829,739.8	2,012,860.2	98.4
210303	Цэвэр, бохир ус	7,000,000.0	6,864,060.5	135,939.5	98.1
2104	Хангамж, бараа материалын зардал	48,200,000.0	46,688,117.1	1,511,882.9	96.9
210401	Бичиг хэрэг	15,000,000.0	14,825,640.0	174,360.0	98.8
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.0	15,000,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,200,000.0	7,709,875.1	490,124.9	94.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000,000.0	9,152,602.0	847,398.0	91.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	107,000,000.0	105,420,955.0	1,579,045.0	98.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.0	15,000,000.0	00.0	00.0
210602	Тавилга	45,500,000.0	44,221,000.0	1,279,000.0	-02.8
210604	Урсгал засвар	46,500,000.0	46,199,955.0	300,045.0	99.4
2107	Томилолт, зочны зардал	18,610,000.0	17,738,000.0	872,000.0	95.3
210702	Дотоод албан томилолт	11,610,000.0	11,610,000.0	00.0	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,000,000.0	6,128,000.0	872,000.0	87.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	496,017,200.0	494,899,831.6	1,117,368.4	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	489,684,400.0	489,464,369.6	220,030.4	100.0

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,612,800.0	1,612,800.0	00.0	00.0
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.0	191,650.0	108,350.0	63.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.0	293,512.0	6,488.0	97.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.0	52,000.0	68,000.0	43.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.0	3,285,500.0	714,500.0	82.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,000,000.0	160,750,732.0	4,249,268.0	97.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	162,000,000.0	158,057,732.0	3,942,268.0	97.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.0	2,693,000.0	307,000.0	89.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,765,400.0	30,764,980.0	420.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,765,400.0	30,764,980.0	420.0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,765,400.0	10,765,400.0	00.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,000,000.0	19,999,580.0	420.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,996,308,800.0	1,980,355,407.8	15,953,392.2	99.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,996,308,800.0	1,980,355,407.8	15,953,392.2	99.2
132001	Орон нутгийн төсвөөс	1,996,308,800.0	1,980,355,407.8	15,953,392.2	99.2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	46.00	46.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	17.00	17.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,257,690.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,257,690.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,257,690.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,127,000.00
210401	Бичиг хэрэг	2,127,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	167,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	167,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,963,490.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,963,490.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	85,257,690.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,257,690.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,952,490.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	74,805,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 83,869.0 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж 1 албан шаардлага, 8 зөвлөмж хүргүүллээ.

5.3 Албан шаардлага

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон бусад арга хэмжээний хоолны зардалд 21,339.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3. сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн албан шаардлага:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Нэмэлт санхүүжилтийн орлоготой холбоотой**

1.1. Илрүүлэлт:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дагуу хураагдсан хөрөнгийг худалдан борлуулсны орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолын 2.10.3 дах хэсэгтэй нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Эрх бүхий байгууллага, албан тушаалтан албадлагын арга хэмжээ авсантай холбогдуулан хураан авсан хөрөнгийг худалдан борлуулж олсон орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлэх

2. **Нэмэлт санхүүжилтийн орлоготой холбоотой**

1.1 Илрүүлэлт:

Хөрөнгө түрээслүүлсний орлого, Илч түлш аяны түлээний орлого, Өвс тэжээлийн орлого зэрэг орлого нь жил бүр төвлөрдөг, төлөвлөх боломжтой орлогууд байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44.4. “Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.” гэсэн заалттай нийцэхгүй ба “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Урьдчилан төлөвлөх боломжтой өөрийн үйл ажиллагааны орлогыг тухайн жилийн төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах

3. **Төсвийн зарцуулалттай холбоотой**

1.1 Илрүүлэлт:

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах 32,000.0 мянган төгрөгийг Мөрөн сумын ЗДТГ-ын төсвөөс санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 6.6.6. тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6. үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн

шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Өөрийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй зардлыг сумын төсөвтэй давхардуулан санхүүжүүлэхгүй байх

4. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой

4.1 Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшилд байгаа газруудын бүртгэлийг E-gazar.gov.mn цахим сайттай тулгалт хийхэд 6712016128 нэгж талбарын дугаар бүхий Мөрөн сумын 6-р багийн нутаг дэвсгэрт байх газар нь Мөрөн сумын ЗДТГ-ын эзэмшилд байхгүй байна. Мөн 2023 онд зарим газрыг тооллогоор илрүүлж бүртгэсэн нь тус байгууллагын газрын албаны холбогдох ажилтнууд болон санхүүгийн албаны уялдаа холбоо муутай байгааг харуулж байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

6712016128 нэгж талбарын дугаар бүхий газрын бүртгэлийг E-gazar.gov.mn цахим сайтад залруулж, холбогдох ажилтнуудын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авч ажиллах

5. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

5.1 Илрүүлэлт:

Байгууллагын дотоод хяналтын нэгжийг 2022 онд шинэчлэн баталсан боловч тайлант онд батлуулсан төлөвлөгөө, тайлан байхгүй байна. Сумын дотоод аудитын нэгжээр хяналт хийлгүүлсэн гэх боловч тус нэгжийн тайлант оны төлөвлөгөө тайланд сумын ЗДТГ дээр хийсэн хяналт байхгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын 2.3. “Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино.” гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын дотоод хяналтын нэгжийг журмын дагуу ажиллуулах

6. Хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой

6.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй биет болон биет бус 69 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь УСНББОУС-17 Параграф 49, УСНББОУС-31 Параграф 78, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т “Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээсээ материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ” гэж заасантай нийцэхгүй байгаа ба “Үнэлгээ” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгөд дахин үнэ тогтоох

7. Худалдан авах ажиллагаатай холбоотой

7.1 Илрүүлэлт:

Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулахдаа мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ болон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг оруулахгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 “Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.” гэсэн заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

7.2 Өгсөн зөвлөмж:

Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ болон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг худалдан авах төлөвлөгөөнд оруулж батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах

8. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

8.1 Илрүүлэлт:

Байгууллагын худалдан авах ажиллагааны тайланг мэдээлэхдээ төсвийн жилийн дундуур орсон төсвийн тодотголын дүнг оруулахгүйгээр зөвхөн оны эхэнд батлуулснаар зөрүүтэй мэдээлсэн, мөн тавилга эд хогшил худалдан авах тендерийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;" гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтийн орлоготой холбоотой	2	8,104.5					2	8,104.5				
Төсвийн зарцуулалттай холбоотой	2	53,339.5			1	21,339.5	1	32,000.0				
Худалдан авах ажиллагаатай холбоотой	1	0.0					1	0.0				
Хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой	2	22,425.0					2	22,425.0				
Дотоод хяналт хариуцлагатай холбоотой	1	0.0					1	0.0				
Дүн	8	83,869.0			1	21,339.5	7	62,529.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой	1	0						1	0
Дүн	1	0						1	0

